


# Монгол Улс, Өмнөговь аймагт Хүн амын хөдөлгөөнийг тандах туршилтын судалгаа

2022 он



© Н.СҮХБАТ



Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарын хөгжлийн агентлаг

Энэхүү тайлан нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр, НҮБ-ын ОУШХБ-аас хэрэгжүүлж буй “Монгол дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудаас гаргаж буй үр дүнгийн нэг хэсэг юм. Энэхүү төслийн зорилго нь Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицыг (ДТМ) ашиглан Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн, хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар нотолгоонд суурилсан томъёолол, хэрэгжилтийг бэхжүүлэн бататгахад оршино. Судалгааны асуултууд болон аргачлал, арга зүйг Үндэсний Статистикийн Хороо, НҮБ-ын ОУШХБ-ын ДТМ судалгааны багийн оролцоотойгоор боловсруулсан. Судалгааны мэдээллийг ОУШХБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн алба болон Глобал ДТМ-ийг дэмжих багийн удирдлагуудын техникийн дэмжлэгтэйгээр Хүн амын Хөдөлгөөнийг тандах матрицын (ДТМ) хэрэглүүрийг ашиглан цуглуулж, дүн шинжилгээ хийсэн.

Уг тайлангийн үр дүн, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд НҮБ-ын ОУШХБ, түүний гишүүн улсууд, Швейцарын хөгжлийн агентлаг болон бусад хандивлагчдын байр суурийг илэрхийлэхгүй болно. Тайлангийн түршид ашигласан тэмдэглэгээ болон материалын танилцуулга нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдлын талаар ОУШХБ-ын зүгээс ямар нэгэн үзэл бодлоо илэрхийлэх, эсхүл түүний эрх баригчид, хил хязгаар, хил хязгаарыг илэрхийлээгүй болно.

НҮБ-ын ОУШХБ нь шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн ам болон нийгэмд тустай, хүмүүнлэг, аюулгүй, цэгцтэй шилжилт хөдөлгөөний зарчмыг баримтлан ажилладаг. НҮБ-ын ОУШХБ нь засгийн газар хоорондын байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн түншүүдтэйгээ дараах зорилтын хүрээнд хамтран ажилладаг. Үүнд: шилжилт хөдөлгөөний үйл явц дахь сорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; шилжилт хөдөлгөөний асуудлын талаар мэдлэг мэдээллээ дээшлүүлэх; шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих; мөн шилжин суурьшигчдын нэр төр, сайн сайхныг дээдлэх.

Энэхүү хэвлэл нь НҮБ-ын ОУШХБ-ын албан ёсны баталгаажуулалтгүйгээр гарсан болно.

Хавтасны зураг: © В.Баттулга, Бямба-Очир, Н.Сүхбат.

Ишлэл: Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ), 2022. Монгол Улс, Өмнөговь аймагт хүн амын хөдөлгөөнийг тандах түршилтын судалгаа

Дэлгэрэнгүй мэдээллийг хэвлэн нийтлэгчээс авна уу.

Нийтлэгч: Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ) - Монгол Улс  
НҮБ-ын байр, 307 тоот  
НҮБ-ын гудамж - 12  
Сүхбаатар дүүрэг  
14201 Улаанбаатар  
Монгол Улс  
Утас: +976 - 70 14 31 00  
Имэйл: IOMUlanbator@iom.int

© ОУШХБ 2022



Зарим эрх хуулиар хамгаалагдсан. Энэхүү бүтээлийг Creative Commons Attribution-NonCommercial-NoDerivs 3.0 IGO лицензийн дагуу (CC BY-NC-ND 3.0 IGO) ашиглах боломжтой. \*

Нэмэлт үзүүлэлтүүдийн талаар зохиогчийн эрх болон ашиглалтын нөхцлийг харна уу.

Энэхүү нийтлэлийг боловсролын зорилгоос бусад тохиолдолд жишээлбэл, эрдэм шинжилгээний сурах бичигт оруулах, ашгийн төлөө худалдаалах, нийтлэх, тараахыг хориглоно.

Зөвшөөрөл: Арилжааны зориулалтаар ашиглах эсвэл нэмэлт эрх, лиценз авах хүсэлтийг publications@iom.int хаягаар илгээх боломжтой.

\*<https://creativecommons.org/licenses/by-nc-nd/3.0/igo/legalcode>

# Агуулга

## Гол дүгнэлтүүдийн хураангуй.....01

Хүн ам.....01

Дотоод шилжилт хөдөлгөөн.....01

## Арга зүй.....02

Судалгааны суурь мэдээлэл.....02

Түүвэрлэлтийн арга.....02

Хязгаарлалтууд.....02

Тодорхойлолтууд.....02

Газарзүйн хамрах хүрээ.....03

Мэдээллийн эх сурвалжууд.....04

## Мэдээллийн дүн шинжилгээ.....05

Хүн ам зүйн мэдээлэл.....05

Дотоод шилжилт хөдөлгөөн.....05

Хөдөлмөр эрхлэлт.....07

## Дүгнэлт.....08

Судалгааны зөвлөмжүүд.....08

Бодлогын зөвлөмжүүд.....08

# 1. Хураангуй

## 1.1 Хүн ам



Хувь хүмүүс



Эмэгтэй




Эрэгтэй

Үнэлгээ хийх үед Өмнөговь аймагт нийт 78,682 хүн амьдарч байсан бөгөөд тэдгээрээс эрэгтэй (52%) болон эмэгтэй (48%) нь хүйсээр бараг тэнцүү хуваагдсан байна. 2022 оны 2-р сард Өмнөговь аймгийн хэмжээнд нийт 1,462 хүн амын хөдөлгөөн ирснээр бүртгэгдсэн бол 1,367 иргэн Өмнөговь болон бусад аймаг, сумд руу явснаар бүртгэгдсэн байна. Ханбогд суманд ажиглалт, тандалтын хугацаанд хамгийн их хүн амын хөдөлгөөн бүртгэгдсэн бөгөөд сумын нийт хүн амын 7 хувийг дангаараа эзэлж байна. Бусад сумтай харьцуулахад ийм өндөр хувь бүхий хүн амын хөдөлгөөн бүртгэгдсэн нь Ханбогд сумын уул уурхайн салбарын хөгжил, улирлын чанартай ажилчдын хөдөлгөөн, үйлчилгээ болон бусад үйл ажиллагаа явуулдаг хүмүүсийн хөдөлгөөнтэй шууд хамааралтай гэж үзэж байна. Хүн амын хөдөлгөөн Гурвантэс, Хүрмэн сумдад мөн өндөр бүртгэгдсэн байна. Өмнөговь аймагт ажилгүйдлийн дундаж түвшин 27 хувьтай байгаа бол энэ үзүүлэлт сум хооронд ихээхэн ялгаатай байна. Ажилгүйдлийн түвшин хамгийн өндөр байгаа сумдад Сэврэй сум (40%), Даланзадгад сум (36%), Баяндалай сум (35%) тус тус бүртгэгдсэн байна.


## 1.2 Хөдөлгөөний урсгал



2022 оны 2-р сар, Ирсэн иргэд хамгийн их бүртгэгдсэн 3 сум



2022 оны 2-р сар, Явсан иргэд хамгийн их бүртгэгдсэн 3 сум



## Ажилгүйдлийн түвшин хамгийн өндөр бүртгэгдсэн 10 сум



## 2. Арга зүй

### 2.1 Судалгааны суурь мэдээлэл

ОУШХБ-ын өмнөх судалгаануудаар газрын доройтол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг асуудлууд нь Монголын уламжлалт амьдралын хэв маягийг өөрчилж байгааг тогтоожээ. Ганзудын давтамж нэмэгдэж, ажлын байр хомс, амьдрах орчин нөхцөл шаардлага хангахгүй, хөдөөгийн хүн ам малаас хэт хараат болсон зэрэг нь хөдөөгийн хүн амын амьжиргааг залгуулах боломжийг өдрөөс өдөрт бууруулсаар байна. Үүний зэрэгцээ энэ байдал нь хот суурин газар болон бусад аймгийн төв рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэх хүчин зүйл болсоор байна. Эдгээр шинээр гарч ирж буй шилжилт хөдөлгөөний (хүн амын хөдөлгөөн) хэв маяг нь тооллогын, бүртгэлийн мэдээлэл болон Монгол Улсын хэмжээнд амьдарч буй хүмүүсийн бодит тоон мэдээлэл хооронд ихээхэн зөрүү үүсгэсээр байна. Энэхүү туршилтын судалгаагаар ҮСХ болон ОУШХБ нь хамтран Өмнөговь, болон Дундговь аймгуудад багийн байршил дээрх хүн амын бодит тоог тандах зорилгоор Хүн амын хөдөлгөөнийг тандах матрицын “Хөдөлгөөний тандалт” – МТ (Mobility Tracking) аргачлалыг ашиглахыг зорьсон юм.

### 2.2 Судалгааны арга зүй

Дээр дурдсан зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд ОУШХБ-ын ДТМ судалгааны багаас боловсруулсан, Хөдөлгөөнийг тандах аргачлалыг ашигласан болно. Хөдөлгөөнийг тандах аргачлал нь хөдөлгөөнт хүн амын тоо, байршил, шилжилт хөдөлгөөний шалтгаан, гарал үүслийн газар нутаг, үндсэн хүн ам зүй, эмзэг байдал, тэргүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход чиглэсэн юм. Мэдээллийг голчлон тухайн нутаг дэвсгэр, дэд бүс нутаг, эсвэл байршлын түвшний гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлагаас олж авдаг бөгөөд боломжтой бол хоёрдогч эх сурвалжийн мэдээллээр давхар баталгаажуулдаг. Энэхүү судалгааны үндсэн асуулга нь 1) хүн амын бодит тоо, 2) шилжилт хөдөлгөөний шалтгаан, хөдөлгөөний хэлбэр, 3) хөдөлмөр эрхлэлт гэсэн гурван үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй. Бусад судалгааны аргачлалууд өрх, хувь хүний мэдээлэлд тулгуурлан мэдээлэл нэгтгэдэг бол Хөдөлгөөнийг тандах судалгааны аргачлал нь байршлын нөхцөл байдалд тандалт хийх замаар энэ тохиолдолд Монгол улсын засаг захиргааны хамгийн жижиг нэгж болох багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амын хөдөлгөөн хэрхэн өөрчлөгдөж байгааг тодорхойлоход чиглэсэн болно. Энэхүү судалгаанд

Багийн Засаг дарга нар гол мэдээлэгчээр ажиллаж, үнэлгээ хийх үед багийн нутаг дэвсгэр дээрх хүн амын нөхцөл байдлын талаар мэдээлэл нөхсөн. Багийн Засаг дарга нар өөрсдийн мэдлэгийн хүрээнд мэдээлэл цуглуулж маягтыг бөглөж, мөн тухайн багийн нутаг дэвсгэр дээр юу болж байгаа талаарх боломжтой бүх мэдээллийг өгч ажилласан байна.

### 2.3 Хязгаарлагдмал байдал

Хөдөлгөөнийг тандах аргачлал нь гол мэдээлэгчдээс өгсөн мэдээлэлд тулгуурладаг бөгөөд энэ шалтгааны улмаас дотоод болон гадаад хүчин зүйл хязгаарлагдмал байх магадлалтай юм. Энэхүү аргачлалыг ашиглан цуглуулсан мэдээлэл нь баримтаас илүү гол мэдээлэгчийн өгсөн тооцоолол, төсөөллийг илэрхийлдэг бөгөөд ажиглалтын нэгжийн хэмжээ, гол мэдээлэгчийн мэдлэгийн төвшнөөс хамаарч харилцан адилгүй байдаг. Нэмж дурдахад, тухайн үнэлгээ хийгдсэн байршлаас зөвхөн нэг мэдээлэгчийн өгөгдөл ашигласан тул үр дүнгийн гурвалжинг хязгаарласан болно. Шаардлагатай тохиолдлуудад мэдээллийн үнэн зөвийг үр дүнгийн гурвалжингаар баталгаажуулсан болно.

### 2.4 Тодорхойлолтууд

үнэлгээ хийх үед тухайн байршилд оршин сууж буй бүх иргэдийг хамруулан ойлгоно. Энэ тоо нь гарал үүсэл, бичиг баримтын нөхцөл байдал, бүртгэл, нас, хүйс, хүн ам зүйн бусад шинж чанараас үл хамааран бүх оршин суугчдыг багтаасан болно.

Өрхийн тодорхойлолт: нэг дээвэр дор амьдарч, зардал, хоол хүнсээ хуваалцдаг хүмүүс.

Дотоод шилжин суурьшигч: Үнэлгээ хийхээс мөн долоо хоногийн өмнө дор хаяж дөрвөн долоо хоног оршин суухаар нэг газраас өөр газар нүүсэн хүн бүр.

## 2.5 Газарзүйн хамрах хүрээ

Энэхүү туршилтын судалгаа нь Өмнөговь аймгийн нийт 15 сумын 59 багуудад хийгдсэн бөгөөд нийт 59 багийн Засаг дарга нар өөрсдийн хариуцан ажиллаж буй багийнхаа хүн амын хөдөлгөөний талаар мэдээллийг нэгтгэн нөхсөн юм (баг бүрт нэг). Мэдээлэлд дүн шинжилгээ хийх явцад багийн түвшний мэдээллийг сум, сумын түвшний мэдээллийг аймгийн хэмжээнд нэгтгэсэн болно.


Сум, аймгийн хэмжээнд голчлон харуулсан энэхүү тайланд тусгагдсан бүх мэдээллийг багийн түвшинд задалж, хамгийн бага засаг захиргааны нэгжийн түвшинд нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй тоймлон харуулах боломжтой. Энэ төрлийн мэдээлэл нь орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилтэнд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

### Газарзүйн хамрах хүрээ

| Аймаг           | Сум         | Баг             | # | Хүн ам* |
|-----------------|-------------|-----------------|---|---------|
| <b>Өмнөговь</b> |             |                 |   |         |
|                 | Баяндалай   | ■ ■ ■           | 3 | 2,090   |
|                 | Баян-Овоо   | ■ ■ ■           | 3 | 1,809   |
|                 | Булган      | ■ ■ ■ ■         | 4 | 2,098   |
|                 | Даланзадгад | ■ ■ ■ ■ ■ ■ ■ ■ | 8 | 29,257  |
|                 | Гурвантэс   | ■ ■ ■ ■ ■       | 5 | 5,281   |
|                 | Ханбогд     | ■ ■ ■ ■ ■       | 5 | 14,329  |
|                 | Хан-Хонхор  | ■ ■ ■ ■         | 4 | 1,633   |
|                 | Хүрмэн      | ■ ■ ■           | 3 | 1,465   |
|                 | Мандал-Овоо | ■ ■ ■           | 3 | 1,627   |
|                 | Манлай      | ■ ■ ■ ■         | 4 | 2,618   |
|                 | Номгон      | ■ ■ ■ ■ ■       | 5 | 2,496   |
|                 | Ноён        | ■ ■             | 2 | 1,373   |
|                 | Сэврэй      | ■ ■ ■           | 3 | 2,033   |
|                 | Цогт-Овоо   | ■ ■ ■           | 3 | 1,954   |
|                 | Цогт-Цэций  | ■ ■ ■ ■         | 4 | 8,619   |


## 2.6 Мэдээллийн эх сурвалжууд

ОУШХБ-ын судалгааны системийн Хөдөлгөөнийг өгөгдөл өгөгдлийн тандах болон зөрүүтэй туршилтын бүртгэлийн байдал



Энэхүү туршилтын судалгааны үндсэн зорилго нь Өмнөговь аймагт (засаг захиргааны нэгж болох багт) тухайн цаг үед амьдарч буй иргэдийн бодит тоон мэдээллийг гаргахад оршино. Гол мэдээлэгчдэд зохион байгуулсан сургалтын үеэр баг бүрд оршин сууж буй иргэдийн бодит тоог бүртгэлийн нөхцөл байдлаас үл хамааран тайлагнахыг зөвлөсөн. Мэдээллийн эх үүсвэрийг давхар тодорхойлох зорилгоор мэдээлэгчээс хүн амын тоон мэдээллийг ямар төрлийн эх сурвалжаас авсан талаар асуусан. Нийтдээ мэдээлэгчдийн 22 хувь нь бүртгэлийн мэдээллийг ашигласан гэж мэдээлсэн бол 25 хувь нь хувийн мэдлэг дээр үндэслэн тандалт хийх замаар мэдээллээ нөхсөн байна. Гол мэдээлэгчдийн (53%) нь тооллогын мэдээллийг ашигласан гэж мэдээлсэн байна. Тооллогын болон бүртгэлийн мэдээллийг ашигласан гол мэдээлэгчдээс яагаад шууд ажиглалтаас илүү энэ мэдээллийн эх сурвалжийг илүүд үзэх болсон талаар мөн асуусан. Нийтдээ 84 хувь нь бүртгэл, тооллогын мэдээлэл зөв гэж хариулсан бол 14 хувь нь мэдээллийн эх сурвалжийг ашиглахаас өөр аргагүй байсан гэж хариулсан байна. Мэдээллийн дүн шинжилгээний явцад ДТМ Хөдөлгөөнийг тандах аргачлалаар тооцсон хүн амын тоог бүртгэлийн тоотой харьцуулсан болно. Хоёр мэдээллийн эх сурвалжийн хооронд дунджаар 10 хувийн зөрүү байгаа бөгөөд үүнд голлон нөлөөлсөн нь Ханбогд сумын хөдөлгөөний нөхцөл байдлын тоон мэдээ байсан юм. Хөдөлгөөнийг тандах аргачлалын тоон мэдээ болон бүртгэлийн мэдээллийн зөрүү 71 хувь байна. Багийн Засаг дарга нарын сонгосон мэдээллийн эх сурвалжаас харахад тооллогын мэдээлэл нь хүн амын тоог тооцоолоход хамгийн бага ашиглагддаг мэдээллийн эх сурвалж байсан юм.

### Ашигласан мэдээллийн үндсэн эх сурвалжууд




### Тооллого болон бүртгэлийн мэдээллийг ашигласан шалтгаанууд




## 3. Мэдээллийн дүн шинжилгээ

### 3.1 Хүн ам зүйн мэдээлэл




Өмнөговь аймгийн хүн ам, насны ангиллаар




### 3.2 Дотоод шилжилт хөдөлгөөн

Туршилтын судалгааны хугацаанд Ирсэн иргэдийн тоо



Хүн амын хөдөлгөөний мэдээлэл нэгтгэх үед Өмнөговь аймагт нийт 78,682 хүн амьдарч байсан гэсэн тооцоо гарсан. Тэдний 66 хувь нь Даланзадгад (37%), Ханбогд (18%), Цогт-Цэций (11%) сумдад бүртгэгдсэн бөгөөд үлдсэн 34 хувь нь бусад 12 суманд амьдарч байна. Энэ тоон мэдээлэлд Өмнөговь аймагт амьдарч буй нийт иргэд нас, хүйс, эрх зүйн байдал, бүртгэлийн нөхцөл байдлаас үл хамааран хамрагдсан. Аймгийн хэмжээнд хүйсийн хуваарьлалт эрэгтэй (52%) болон эмэгтэй (48%) нь байсан нь энэ тэнцүү хуваагдсан харагдаж байна. Харин Ханбогд суманд эмэгтэйчүүдийн эзлэх хувь Өмнөговь аймгийн дунджаас эрс ялгаатай буюу нийт хүн амын ердөө 39 хувийг эзэлж байна. Үүнийг ажил эрхэлж буй хүн амын 70 орчим хувь нь уул уурхай, тээврийн салбарт ажилладаг Ханбогд сум дахь хөдөлмөрийн зах зээл өндөр сегментчилсэнтэй холбон тайлбарлаж болох юм. Насны хувьд 0-17 насны насанд хүрээгүй хүүхдүүд Өмнөговь аймгийн нийт хүн амын 34 хувь, 18-65 насны насанд хүрэгчид хүн амын 61 хувь, 66 ба түүнээс дээш насны хүн ам 5 хувийг эзэлж байна. Сумын хэмжээнд Цогт-Цэций сум насанд хүрээгүй хүүхдүүдийн дийлэнх хувийг (44%) эзэлж байгаа бол Цогт-Цэций сум нь уул уурхайн салбарт ажиллагсдын хамгийн өндөр хувьтай сумдын нэгээр бүртгэгдсэн юм. Мөн түүнчлэн Мандал-Овоо (18%), Баян-Овоо (10%) сумдад өндөр настан хамгийн их бүртгэгдсэн байна.


Туршилтын судалгааны хугацаанд Явсан иргэдийн тоо





Багийн Засаг дарга нар өмнөх 4 долоо хоногийн хугацаанд өөр газар нутгаас хамгийн багадаа нэгээс доошгүй сарын хугацаагаар амьдрахаар ирсэн болоод явсан хүмүүсийн тоог 2021 оны 12-р сараас 2022 оны 2-р сар хүртэлх хугацаанд мэдээлсэн. Энэ төрлийн хөдөлгөөний урсгалд сар бүр ажиглалт хийснээр улирлын шинж чанартай хүн амын хөдөлгөөнийг тодорхойлох боломжтой юм. Дотоод хүн амын хөдөлгөөн 2021 оны 12-р сард хамгийн бага бүртгэгдсэн бол 1-р сард дээд цэгтээ хүрч 2-р сард дахин буурсан байна. 1-р сард бусад саруудтай харьцуулахад оргил үе тохиож байсан нь сар шинийн баяр, наадамтай холбоотой хөдөлгөөн байж болох юм. 2022 оны 2-р сард нэгтгэсэн мэдээллээс харахад 15 сумын 9-д нь хүн амын хөдөлгөөний урсгал бүртгэгдсэн байна. Нийт хүн амын хэмжээнд харьцуулахад хамгийн их хэмжээний хүн амын хөдөлгөөн Ханбогд (7%), Гурвантэс (3%), Хүрмэн (2%) сумдад ирснээр бүртгэгдсэн байна. Хамгийн их явснаар бүртгэгдсэн хөдөлгөөний урсгал Ханбогд (7%), Гурвантэс (2%), Манлай (2%) сумдад бүртгэгджээ. 2022 оны 2-р сард Өмнөговь аймгийн сум, багуудад ирсэн иргэдийн гол шалтгаан нь гэр бүлийн шалтгаан (54%), эдийн засгийн шалтгаан (19%), боловсролын шалтгаанууд (11%) байна. Хөдөлмөр эрхлэлт хүн амын хөдөлгөөний гол хүчин зүйл болсон байршлын дэд бүлгийг авч үзвэл уул уурхайн салбарын ажил хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хөдөлгөөн зонхилж байна.

Өмнөговь аймаг руу нүүх болсон үндсэн шалтгаанууд Өмнөговь аймаг руу нүүх болсон шалтгаанууд, сумд



### 3.3 Хөдөлмөр эрхлэлт

#### Ажилгүйдлийн түвшин





**27%**

үнэлгээ хийх үед ажилгүй байсан хүмүүс

Өмнөговь аймагт ажилгүйдлийн түвшин 2 сарын тоон мэдээгээр 27 хувьтай байсан. Ажилгүйдлийн түвшин хамгийн өндөр бүртгэгдсэн сумдууд Сэврэй (40%), Даланзадгад (36%), Баяндалай (35%) байсан бол хамгийн бага бүртгэгдсэн сумдууд Цогт-Овоо (3%), Ноён (6%), Хүрмэн (10%) байна. Уул уурхайн салбар нь эдийн засгийн хөгжилд нөлөөлөх чухал салбар учраас энэхүү туршилтын судалгаагаар сум, багийн хэмжээнд уул уурхайн салбарт ажиллаж буй хүмүүсийн эзлэх хувийг харуулахыг зорьсон. Хөдөлмөр эрхэлж буй нийт хүн амын тоон үзүүлэлтээс зөвхөн уул уурхайн салбарт ажил хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эзлэх хувь Ханбогд (68%), Цогт-Цэций (58%), Даланзадгад (24%), Гурвантэс (13%), Баян-Овоо (13%) байна.

#### Ажилгүйдлийн түвшин сумдаар



## 4. Дүгнэлт

Энэ туршилтын судалгаа нь хүн амын бодит тоон мэдээллийг тооцоолох, өгөгдлийн эх сурвалжууд, түүний ашиглалт, нарийвчлалыг харьцуулах, мөн ажилгүйдлийн нөхцөл байдлыг байршил тус бүрээр гаргахыг зорьсон.

### 4.1 Судалгаанаас гарсан зөвлөмж

**Өмнөговь аймагт хэрэгжүүлсэн Хүн амын хөдөлгөөнийг тандах ДТМ судалгааг Улсын хэмжээнд зохион байгуулах.**

Энэхүү туршилтын судалгааны үр дүнд тулгуурлан судалгааны газарзүйн цар хүрээг өргөжүүлж, Монгол Улсын хэмжээнд зохион байгуулахыг зөвлөж байна. Үүгээр хөгжлийн төлөвлөлт, цааш цаашдын судалгаанд ашиглагдаж болох төрөл бүрийн сэдэвчилсэн мэдээллийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой. Түүнчлэн уг судалгаа нь Монгол Улс, тэр дундаа хүн амын шилжилт хөдөлгөөн, ажилгүйдлийн түвшин өндөр байгаа бүс нутгуудын бүртгэлийн нөхцөл байдлын талаар илүү нарийвчилсан дүр зургийг гаргах болно. Бодлогын үүднээс, энэхүү судалгаа нь бодит хэрэгцээнд тулгуурласан үйл ажиллагааг тодорхойлоход ач холбогдолтой.

**Хүн амын хөдөлгөөнийг тандах ДТМ аргачлалаар нэгтгэсэн мэдээллийг ашиглан тодорхой байршилд богино хэмжээний давтан судалгааг зохион байгуулах.** ДТМ хөдөлгөөнийг тандах судалгаагаар цуглуулсан мэдээллийг ОУШХБ, Засгийн газар болон бусад оролцогч талуудад мэдээллийн дутмаг байдал, хэрэгцээ шаардлага, цаашдын хөгжлийн чиг хандлагыг мэдээлэхэд ашиглаж болно.

**Шаардлагатай бол өгөгдөл, судалгааны дутуу мэдээллийг нөхөхийн тулд судалгаанд нэмэлт судалгааны модулиудыг оруулах.**

Энэхүү судалгаанд хамгийн энгийн асуулгыг ашигласан ба асуулгыг өргөжүүлэх боломжтой. Судалгааг үйлчилгээний хүртээмж, аюулгүй байдал, санхүүгийн байдал, тээврийн хэрэгсэл, орлого зэрэг үзүүлэлтүүдийг багтааж өргөжүүлж болно.

### 4.2 Бодлогын зөвлөмжүүд

**Мэдээллийн эх сурвалжууд:** ДТМ туршилтын судалгааны өгөгдөл болон бүртгэлийн мэдээллийн хооронд ялгаа байгаа хэдий ч бүртгэлийн мэдээллийг гол мэдээлэгчид хүн амын тоог тайлагнахдаа ховор ашигладаг болохыг тэмдэглэв. Энэхүү дүгнэлтээс харахад бүртгэлийн мэдээлэл Өмнөговь аймгийн багуудад амьдарч буй иргэдийн бодит тоог бүрэн тусгаж чадахгүй байна. Ийм учраас орон нутгийн хэмжээнд бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, хамгийн их зөрчилтэй байсан Ханбогд, Хан-Хонхор сумдад шинэ арга, аргачлал нэвтрүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

**Дотоод шилжилт хөдөлгөөн:** Энэхүү судалгаагаар тайлант хугацаанд дотоод хүн амын хөдөлгөөн гол төлөв гэр бүлийн шалтгаанаас үүдэлтэй болохыг тогтоожээ. Харин дотоодын ирэх, явах шилжилт хөдөлгөөн хамгийн өндөр нь уул уурхайн салбартай Ханбогд сум байна. Үүнээс үзэхэд уул уурхайн салбарт хөдөлмөр эрхлэлт нь дотоод шилжилт хөдөлгөөнд шууд нөлөө үзүүлж байгаа бөгөөд хөдөлгөөний урсгалд хэрхэн нөлөөлж буйг ойлгох нь хөгжлийн төлөвлөлт, хариу арга хэмжээний гол түлхүүр юм.

**Ажил эрхлэлт:** Ажилгүйдлийн түвшин Сэврэй, Даланзадгад, Баяндалай сумдад хамгийн өндөр бүртгэгдсэн бол ажилгүйдлийн түвшин хамгийн бага байгаа газар нь Цогт-Овоо, Ноён сумд байна. Эдгээр хоёр өөр нөхцөл байдал бүхий сумдыг судалж, туршлага, хөдөлмөр эрхлэлтийн стратеги, тогтолцоог харьцуулахыг санал болгож байна.

